

МОНГОЛ УЛС ДАХЬ ЭРҮҮГИЙН ПРОЦЕССЫН ЭРЭН СУРВАЛЖЛАХ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ



ANALYSIS OF INVESTIGATION IN CRIMINAL PROCEDURES IN MONGOLIA

П.Батбаатар*

ЦЕГ-ын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны дарга, Дотоод хэргийн их сургуулийн докторант, цагдаагийн хурандаа,

Pol. Col. Batbaatar P, Head, Information Analysis and Operation Management Department of National Police Agency of Mongolia, Ph.D Candidate, University of Internal Affairs

П.Монхтуяа

Хөдөө аж ахуйн их сургуулийн Статистик-Эконометрикийн тэнхимийн ахлах багш, доктор Munkhtuya P, Ph.D, Senior Lecturer, Department of Statistics-Econometrics, School of Economics and Business (SEB), Mongolian University of Life Sciences

*Хариуцлагатай зохиогч: purev.batbaatar7585@gmail.com

Хураангуй: Эрх зүйн шинэчлэл нь 1990 оноос хойш эрчимтэй явагдаж байгаа хэдий ч “Эрэн сурвалжлах ажиллагаа”-ны талаар тухайлсан хууль, зохицуулалт төдийлөн боловсронгуй болоогүй байна. Цагдаагийн албаны тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Гүйцэтгэх ажлын тухай хуулиудад “Эрэн сурвалжлах ажиллагаа”-ны талаар өөр өөрөөр, харилцан уялдаагүй хуульчилж өгсөн бөгөөд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар ч мөн ажиллагааг явуулах шаардлага үүсдэг байна.

Иймд энэхүү сэдвээр эрүүгийн процесс дахь эрэн сурвалжлах ажиллагааг тухайлан авч үзэж, ялгамж, онцлогийг тодорхойлохын тулд SWOT шинжилгээний арга тохиромжтой гэж үзсэн бөгөөд энэ нь эрэн сурвалжлах ажиллагааны дотоод орчны давуу болон сул тал, гадаад орчны боломж, аюул заналыг үнэлж, гүйцэтгэл, үр дүнг сайжруулах, менежментийн шинжилгээ хийж, стратегийн үнэлгээ өгөхөд үр дүнтэй гэж үзсэн болно. Тодруулбал, Монгол Улс дахь Эрүүгийн процессын эрэн сурвалжлах ажиллагааны дотоод, гадаад хүчин зүйл, тэдгээрийн давуу болон сул талыг улс төр, эдийн засаг, нийгэм сёёл, техник технологи, хууль эрх зүйн болон хүрээлэн буй орчны талаас задлан шинжилж, боломж болон аюул эрсдэлийн түвшнийг тодорхойлж, нэгтгэн дүн шинжилгээ хийсэн болно.

Монгол Улсын Эрүүгийн процессын эрэн сурвалжлах ажиллагаанд SWOT шинжилгээ хийсний үр дүнд цаашид олон улсын хэмжээнд болон гадаадын улс орнуудад хэрэгжүүлж буй эрүүгийн процессын эрэн сурвалжлах ажиллагааны эрх зүйн орчин, практик туршлагатай харьцуулан дүн шинжилгээ хийх угтвар нөхцөлийг хангаж, манай улсад авч хэрэгжүүлэх эрх зүйн болон үр дүнтэй туршлагыг тодорхойлон хэрэгжүүлэх боломжтой болох юм.

Abstract: Although the legal reform has been intensively carried out since 1990, the laws and regulations related to "Investigation" have not been sufficiently developed. Laws on Police Service, Criminal Procedure, and Enforcement Laws legislate differently and inconsistently about "Investigative Procedures," and the Civil Procedure Law also requires the procedure to be conducted.

Therefore, in order to consider the investigative process in the criminal process in detail and to determine the differences and features, the SWOT analysis method is considered suitable, which evaluates the strengths and weaknesses of the internal environment of the investigative process, the opportunities and threats of the external environment, and improves performance and results. , is considered effective for conducting management analysis and strategic evaluation. Specifically, the internal and external factors of criminal process investigation in Mongolia, their strengths and weaknesses are analyzed from political, economic, social, cultural, technological,



МОНГОЛ УЛСЫН ХААНЫ СҮРВАЛЖЛАЛЫН АДМИНИСТРИГЧИЛГЭЭН ЦАГДААГИЙН ХӨДЛӨЛ

legal and environmental aspects, and the level of opportunity and danger is determined. , is summarized and analyzed.

As a result of the SWOT analysis of criminal process investigation in Mongolia, the legal framework and practical experience of the criminal process investigation carried out internationally and in foreign countries will provide the prerequisites for analysis, and legal and effective measures to be implemented in our country. It will be possible to identify and implement the experience.

Түлхүүр үгс: Эрэн сурвалжлах ажил, давуу тал, сул тал, боломж, аюул занал.

Keywords: Search operation, strengths, weaknesses, opportunities, threats.

Үндэслэл

Эрэн сурвалжлалтын ажил гэдэг нь өргөн утгаараа оргон зайлсан, сэргэгдэх үндэслэл бүхий этгээд, сэжигтэн, яллагдагч, сураггүй алга болсон хүн, хуулийн этгээд, бусад эрэн сурвалжлагдаж байгаа этгээдүүдийг илрүүлэн олж тогтоох, албадлага хэрэглэхэд чиглэгдсэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Гүйцэтгэх ажлын тухай хууль болон холбогдох бусад хууль, эрх зүйн актын дагуу эрх бүхий субъектүүдээс явуулж буй эрүүгийн тагнуулын, эрүү, иргэн, зөрчлийн процессын арга хэмжээний нэгдсэн тогтолцоо (Б. Лхагварагчаа, П. Эрдэнэбаяр, А. Дэлгэрбаяр нар "Эрүүгийн процессын эрх зүй", 2021) гэж сүүлийн үеийн судлаачид тодорхойлсон байна.

Гүйцэтгэх ажлын тухай хуульд “Эрэн сурвалжлах ажил” гэдэг нь Тагнуулын байгууллага цагдаа, хорих ял эдлүүлэх байгууллагад Эрүүгийн байцаан шийтгэх хууль болон бусад хууль тогтоомжоор харьяалуулсан эрүүгийн хэргийг илрүүлэх, түүнийг үйлдсэн этгээдийг олж тогтоох чиглэлээр хийх нууц ажиллагааг ойлгоно (Legalinfo, Гүйцэтгэх ажлын тухай хууль, 1997) гэсэн нь хуулийн нэр томъёоны хувьд Эрүүгийн байцаан шийтгэх хууль хүчингүй болоод даруй 6 жил өнгөрсөөр атал шинэчлэгдээгүй харуулж байна.

Монгол Улсад Эрүүгийн эрэн сурвалжлах ажиллагааг дараах байдлаар зохион байгуулж иржээ. Тухайлбал,

1. Орон нутгийн эрэн сурвалжлалт (орон нутгийн эрэн сурвалжлалт нь нэг субъектийн харьяалах нутаг дэвсгэрт гүйцэтгэх лавлах тоо

бүртгэлийн мэдээлэх журмыг уг нутагтаа ашиглахаар зарлан явуулах).

2. Бус нутгийн хэмжээний эрэн сурвалжлалт (тодорхой нутаг дэвсгэрийн цагдаагийн хэд хэдэн байгууллагын хүч, хэрэгслээ төвлөрсөн байдлаар ашиглаж зохион. Орон нутгийн эрэн сурвалжлалтын боломж барагдсан буюу эрэн сурвалжлагдаж байгаа этгээдийн нийгмийн аюул ихэссэн үед зохиох).

3. Улсын хэмжээний хэмжээний эрэн сурвалжлалт (орон нутгийн болон бүсчилсэн эрэн сурвалжлалтын үед зохион байгуулсан үйл ажиллагаа үр дүнд хүрээгүй, уг арга хэмжээг шийдвэрлэх, өргөн цар хүрээтэй улс орон даяар зохион байгуулах, цагдаагийн бүх албад нэгжүүдийг хамруулан зохион байгуулах шаардлагатай болсон үед буюу эрэн сурвалжлагдаж байгаа этгээд хаана байгаа нь тодорхой биш байгаа нөхцөлд зохиох).

4. Олон улсын хэмжээний эрэн сурвалжлалт (тус улсын хилийн гадна байгаа эрэн сурвалжлагдагч этгээдийг тухай орны хууль сахиулах байгууллагын оролцоотойгоор олж илрүүлэхээр Монгол Улсын Цагдаагийн Ерөнхий газрын дэргэдэх Интерполын үндэсний төв товчоогоор зуучлуулан зохиох).

Үндсэн хэсэг

Мөрдөгч дараах хүн, хуулийн этгээд, эд зүйл, хөрөнгийг олох зорилгоор эрэн сурвалжлах ажиллагааг өөрийн санаачилгаар, эсхүл шүүхийн шийдвэр, прокурорын даалгавраар явуулахаар эрүүгийн процессын хуульд заасан байна. Тухайлбал,

- Байгаа газар нь мэдэгдэхгүй байгаа сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогч, иргэний хариуцагч, гэрч,



МОНГОЛ УУДААСАН ХУУЛЬ САХИУЛАХАЙ


- Оргон зайлсан сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч,
- Хулгайлагдсан, барьцаалагдсан хохирогч,
- Хэн болох нь тодорхойгүй цогцсыг тогтоох,
- Эмнэлгээс оргосон сэтгэцийн өвчтэй хүн,

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхд ач холбогдол бүхий эд зүйл, мал, амьтан, баримт бичиг, тээврийн хэрэгсэл зэрэг, хүн, хуулийн этгээд, эд зүйл, хөрөнгийг олох зорилгоор эрэн сурвалжлах ажиллагааг өөрийн санаачилгаар, эсхүл шүүхийн шийдвэр, прокурорын даалгавраар тус тус явуулдаг эрх зүйн зохицуулалттай (Legalinfo,

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2017) байна.

Эрэн сурвалжлах ажиллагааны PESTLE буюу макро гадаад орчны нөлөөлөх хүчин зүйлийг судалж улс төрийн орчин (Political), эдийн засгийн орчин (Economic), нийгэм-соёлын орчин (Sociocultural), техник-технологийн орчин (Technological), хуулийн орчин (Legal), хүрээлэн буй орчны (Environmental) хүчин зүйлийг илэрхийлэхийг зорьсон болно.

Энэхүү судалгаагаар SWOT ангилаал тус бүрд PESTLE шинжилгээнд холбогдох үзүүлэлтүүдийг системтэйгээр бүлэглэн үнэлж, гадаад болон дотоод хүчин зүйлүүдийн үндсэн 2 категорийн хүрээнд шинжилгээ хийллэ. (Зураг 1)



Зураг 1. Эрэн сурвалжлах ажиллагааны судалгааны хүрээ

Нэг. ДОТООД ОРЧНЫ ХҮЧИН ЗҮЙЛ

Эрүүгийн процессын эрэн сурвалжлах ажиллагааны давуу болон сүл талуудаар тодорхойлогддог үндсэн шинж

чанаруудыг багтаасан дотоод орчны шинжилгээг хийлээ.

1. ДАВУУ ТАЛ

Улс төрийн орчны давуу тал:

Цагдаагийн албаны тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Гүйцэтгэх ажлын тухай хуулиудад “Эрэн сурвалжлах ажиллагаа”-ны талаар хуульчилсан ба уг ажиллагааг улс төрийн нам, засгийн газрын нөлөөнөөс үл хамааран эрх зүйн тогтвортой орчинд хэрэгжүүлдэг.

Монгол Улсын Засгийн газрын 1991 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн хуралдаанаар “Интерполд элсэн орох тухай” асуудлыг шийдвэрлэж, мөн оны 11 дүгээр сард Ургувай Улсад зохион байгуулагдсан Интерполын Ерөнхий ассамблейн 60 дугаар чуулганаар Монгол Улс Интерполд 155 дахь гишүүн орноор элсэн орсноор (ЦЕГ, Монгол Улсын цагдаагийн байгууллагын түүх, 2021) Үндэсний төв товчоогоор дамжуулан бусад гишүүн орнуудын цагдаа болон хууль сахиулах байгууллагатай гэмт хэргийн талаар мэдээ, мэдээлэл солилцох, гэмт этгээдийг эрэн сурвалжлах, олж тогтоох боломж бүрдсэн.

Манай улс Интерполд гишүүн орноор элсэн орсноос хойш уг чиг үүргийг хэрэгжүүлдэг бие даасан нэгж байгаагүй бөгөөд улмаар “Интерполын үндэсний төв товчоо”-г байгуулж (Цагдаагийн ерөнхий газрын даргын 2012 оны 234 дүгээр тушаал.), олон улсын Эрүүгийн цагдаагийн байгууллага-Интерполын өмнө хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх, гадаад орны цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах, тэдгэрээс хүлээн авсан мэдээ, мэдээллээр цагдаагийн байгууллагыг хангах, гэмт хэрэг үйлдээд оргон зайлсан этгээд, сураггүй алга болсон хүнийг олон улсын хэмжээнд эрэн сурвалжлах, гэмт хэрэг, гэмт этгээдийн талаар мэдээлэл солилцох чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Монгол Улсын Засгийн газраас 2023-2024 оныг “Авлигатай тэмцэх жил” болгон зарлаж (Засгийн газрын 2023 оны 49 дүгээр тогтоол.), уг тогтоолын хавсралтаар “Авлигатай тэмцэх таван үйл ажиллагаа”-г баталсан. Уг ажиллагааны нэг болох “Шувуу ажиллагаа”-ны хүрээнд эрүүгийн

хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гадаад улс руу оргон зайлсан этгээдийг Монгол Улсын олон улсын гэрээ, хууль тогтоомжийн хүрээнд эргүүлэн авчрах, хариуцлага хүлээлгэх ажлыг зохион байгуулж (Засгийн газрын 2023 оны 49 дүгээр тогтоол.) байна.

Эдийн засгийн орчны давуу тал:

Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 30.5 дугаар зүйл, Цагдаагийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлд гэмт хэргийн мэдээллийг төлбөртэй авах талаар тусгаж, мөн зүйлийн 39.3-д заасны дагуу Хууль зүй, дотоод хэргийн сайд, Сангийн сайдын хамтарсан тушаалаар “Иргэд, байгууллагаас төлбөртэй мэдээлэл авахад баримтлах үнэлгээний жишиг”-ийг баталж (Хууль зүй, дотоод хэргийн сайд, Сангийн сайдын 2017 оны А-297,360 дугаар хамтарсан тушаал.), эрэн сурвалжлах ажиллагааг эдийн засгийн баталгаагаар хангасан.

Мөн цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журамд эрэн сурвалжлах ажиллагааны зардлыг тусгаж (ЦЕГ, Эрэн сурвалжлах журам, 2024), жил бүрийн инфляцтай уялдуулан нэмэгдүүлж байгаа нь эрэн сурвалжлах ажиллагааг зохион явуулахад эдийн засгийн дэмжлэг үзүүлж буй хэлбэр юм.

Нийгэм-соёлын орчны давуу тал:

Эрэн сурвалжлалт хариуцсан алба хаагч нь цагдаагийн төв байгууллагын удирдлагын зөвшөөрлөөр Хэвлэл мэдээллийн асуудал хариуцсан нэгжээр дамжуулан цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журамд заасан хүнийг цахим орчинд олон нийтэд зарлан мэдээлдэг (ЦЕГ, Эрэн сурвалжлах журам, 2024). Манай улсын иргэдийн хувьд цахим мэдээллийн хэрэгслийг ихээр ашигладаг ба 2.3 сая хүн буюу нийт хүн амын 65.8 хувь нь фейсбуукийн ашигладаг гэсэн судалгаа байдаг

(www.worldpopulationreview.com/country-rankings/facebook-users-by-country.., n.d.). Өнөө цагт эрэн сурвалжлагдаж буй хүний зөвшөөрөгдсөн мэдээллийг цахим орчинд мэдээлэх, олон нийтийн итгэлийг олох нь мэдээлэл цуглуулах, хамтран ажиллахад дэмжлэг болдог төдийгүй тухайн хүний



МОНГОЛ УЛСЫН ИНТЕРПОЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН 2012 ОНЫ 234 ДҮГЭЭР ТУШААЛ



МОНГОЛ УУДААСАН ТУХАЙ ХУУЛЬ

богино хугацаанд олж тогтоох нөхцөл бүрдсэн.

Техник-технологийн орчны давуу тал:

Цагдаагийн байгууллага нь эрэн сурвалжлах ажиллагааг харилцаа холбооны хэрэгслээр, эрэн сурвалжлалтын сангийн сүлжээгээр, маягт олшуулах гэх мэт хэлбэрээр зохион байгуулж байна. Үүнээс “ASAP” цахим санг (ASAP, 2011) 2011 оноос хойш үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн бөгөөд эрэн сурвалжлагдаж буй хүн, мал амьтан, цогцос, эд зүйлийн мэдээллийг бүртгэх, хянах, засварлах, хадгалах, хамгаалах, эрх бүхий алба хаагчдад дэмжлэг үзүүлэх болон уг санд орсон мэдээллийг үйл ажиллагаандаа ашиглах, дун шинжилгээ хийх, нийт цагдаагийн байгууллага, албан тушаалтан, иргэдэд мэдээлэл хүргэх зорилгоор ашиглаж байна.

Цагдаагийн байгууллагын эрэн сурвалжлах “ASAP” санг ашиглаж эхэлсэн үеэс буюу 2011 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2024 оны 10 дугаар сарын 23-ны өдрийг хүртэл хугацаанд хүн, мал амьтан, эд зүйлийн 370,517 мэдээллийг бүртгэж, зарлан мэдээлснээс 343,062 хүн, мал амьтан, эд зүйлийн эрэн сурвалжлалтыг зогсоож, одоо үлдэгдэл 27,455, эрэн сурвалжлах ажлын илрүүлэлт 92.6 хувьтай байна (ASAP, 2011).

Хуулийн орчны давуу тал:

Цагдаагийн албаны тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд “Эрэн сурвалжлах ажиллагаа”-ны зорилго, ангилал, зохион байгуулах хэлбэр, үр дүнг танилцуулах, олон нийтэд мэдээлэх талаар тусгаж (Legalinfo, Цагдаагийн албаны тухай хууль, 2017), Гүйцэтгэх ажлын тухай хуульд Цагдаагийн байгууллагаас эрэн сурвалжлах ажиллагаа явуулах 6 үндэслэлийг зааж (Legalinfo, Гүйцэтгэх ажлын тухай хууль, 1997) өгсөн байdag.

Дээрх хуулийн хүрээнд Цагдаагийн байгууллага, алба хаагчийн эрэн сурвалжлах үүргээ гүйцэтгэх хөдөлмөр зохион байгуулалт, эрх, үүрэг, хариуцлага, мэдээллийн сан бүрдүүлэх, үйл ажиллагаандаа ашиглахтай холбоотой харилцааг зохицуулах зорилгоор цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны

журмыг анх 2017 онд баталж (Legalinfo, Гүйцэтгэх ажлын тухай хууль, 1997), мөрдөж эхэлсэн бөгөөд хэрэгжүүлэх хугацаандаа буюу 2019-2023 онуудад үйл ажиллагаагаа сайжруулах, алдаа хийдлийг арилгах чиглэлээр нийт 6 удаа нэмэлт, өөрчлөлт оруулан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна.

Цагдаагийн албаны тухай хуульд гэмт хэрэгт сэргэдгэж, эрэн сурвалжлагдаж байгаа иргэний мэдээллээс олон нийтэд зарлаж болох мэдээллийг зааж (Legalinfo, Цагдаагийн албаны тухай хууль, 2017), “Цагдаагийн алба хаагчийн үндэслэл бүхий сэжиг нь хуульд заасан ажиллагааны явцад батлагдаагүй нь тухайн алба хаагчид хариуцлага хүлээлгэх үндэслэл болохгүй.” (Legalinfo, Цагдаагийн албаны тухай хууль, 2017) гэж зохицуулсан байдаг. Цагдаагийн албаны тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд зааснаар мэдээллийн эзний зөвшөөрөл шаардахгүйгээр (Legalinfo, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, 2021) тухайн этгээдийн мэдээллийг эрэн сурвалжлах ажиллагааны явцад олон нийтэд мэдээлж болох эрх зүйн зохицуулалт хангалттай тусгагдсан. Өөрөөр хэлбэл эрэн сурвалжлагдаж байгаа хүнийг шуурхай олж тогтоох зорилгоор тухайн иргэний хувийн мэдээллийг цахим болон бусад мэдээллийн хэрэгслээр олон нийтэд зарлах хууль, эрх зүйн орчин бүрдсэн.

Хүрээлэн буй орчны давуу тал:

Манай улсын хүн ам 3,396,788, нутаг дэвсгэрийн хэмжээ 1,564,116 км² ба нийт хүн амын 1,640,781 буюу 48.3 хувь нь Нийслэлд оршин суудаг (www.1212.mn/statistic/)гэх тоон судалгаа байдаг. Нийт хүн амын дийлэнх хувь нийслэл, аймаг, сумын суурьшлын бүсэд амьдардаг тул эдгээр нь гэмт хэрэгт эрэн сурвалжлагдаж буй этгээдийг шуурхай олж тогтоох, илрүүлэхэд давуу тал болдог.

2. СУЛ ТАЛ

Улс төрийн орчны сул тал:

Аливаа улс орны эрх зүй, төрийн байгууламжаас шалтгаалан мөрдөн шалгах ажиллагааны тогтолцоог цагдаа /мөрдөн



МЭДЭЭЛЛИЙГ
СУРВАЛЖЛАГДАХ
ХҮЧИЙН
ОРЧНЫ СУЛ ТАЛ

байцаах/ болон шүүх төвтэй гэсэн хоёр төрөлд хуваадаг бөгөөд эдгээр нь арга барилын хувьд ялгаатай боловч хүний эрхийг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх, хэрэг, маргааныг түргэн шуурхай шийдвэрлэх гэсэн суурь зарчим, эцсийн зорилгын хувьд ижил юм. Мөрдөн шалгах тогтолцоо нь манай улсын тухайд мөрдөн шалгах, прокурорын байгууллагын өдөр тутмын ажил хэргийн шаталсан харилцаан дээр суурилсан, төрөөс үнэнийг тогтоох процесс бөгөөд гол онцлог нь цагдаагийн байгууллагад эрэн сурвалжлах, мөрдөн шалгах ажиллагааны өндөр ачаалал даалгасан байdag.

Эрэн сурвалжлах ажиллагаа нь гэмт хэрэг үйлдсэн этгээд, эд зүйлийг олж тогтоох, улмаар “Хүн” рүү чиглэсэн нотлох ажиллагаа явуулах зорилготой учраас шүүхэд хэргийг шилжүүлэхээс өмнөх байгууллага, иргэдийн дэмжлэг, хамтын ажиллагаанд тулгуурласан цогц арга хэмжээг хамардаг боловч уг ажиллагааны 90 гаруй хувийг цагдаагийн байгууллага хариуцан хэрэгжүүлдэг (Dr. Anand. K. Deshmunk, Adversarial and Inquisitorial Models of Criminal Justice System: A Comparative Analysis, International Journal of Legal Science & Innovation, 2022).

Цагдаагийн байгууллагад эрэн сурвалжлах чиг үүргийг хэрэгжүүлж буй алба хаагчдад тусгай мэдлэг, боловсрол шаардлагатай бөгөөд тэдний мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх ажил төдийлөн хийдэгтүй тул мэргэжлийн боловсон хүчин дутагдалтай байдаг. Алба хаагчдыг гадаад улсад мэргэшүүлэх сургалтад хамруулах, Интерполын ажилтан, сургагч багш нарыг урьж энэ чиглэлээр сургалт, зөвлөгөөн зохион байгуулах боломж, нөхцөл нь нээлттэй байдаг боловч гагцхүү төсөв, санхүүгийн бэрхшээлтэй, төр засгийн оролцоо, дэмжлэг дутмаг байна.

Эдийн засгийн орчны сул тал:

“Иргэд, байгууллагаас төлбөртэй мэдээлэл авахад баримтлах үнэлгээний жишиг” (Хууль зүй, дотоод хэргийн сайд, Сангийн сайдын 2017 оны А-297,360 дугаар хамтарсан тушаал.) -ийн шалгуурт 4 төрлийн мэдээлэл, түүний мөнгөн дүнг тодорхойлсон боловч эрэн сурвалжлагдаж

байгаа хүний талаарх мэдээллийг төлбөртэй авах талаар тусгагдаагүй. Иймд өнөөгийн нөхцөл байдалд эрэн сурвалжлагдаж байгаа хүнийг олж тогтооход шаардагдаж буй зардлыг “Гүйцэтгэх ажлын санхүүжилт”-ээс олгож байна.

Мөн дээрх жишигт заасны дагуу баримт бичиг бүрдүүлэх, эрх бүхий албан тушаалтуудаас зөвшөөрөл авах, иргэдэд тухайн мөнгийг олгох зэрэг үйл явц нь эрэн сурвалжлах ажиллагаа явуулах эрх бүхий албан тушаалтанд хүндрэл, чирэгдэл үүсгэж, уг ажиллагааг шуурхай зохион байгуулахад сөргөөр нөлөөлдөг.

Нийгэм-соёлын орчны сул тал:

Эрэн сурвалжлагдаж буй хүний мэдээллийг олон нийтэд мэдээлэх нь тухайн хүний гэр булийн гишүүд болон ойр дотныих нь хүмүүсийг нийгэмд ялгаварлан гадуурхах, нэр төрийг нь гутаан доромжлох, сэтгэл зүйн дарамтад оруулж болзошгүй.

Тодорхой гэмт хэрэгт эрэн сурвалжлагдаж буй этгээдийн мэдээллийг цахим орчинд мэдээлснээр тухайн хүн өөрөө болон ойр дотныихоо хүмүүсээс мэдээлэл авах, цаашлаад хөдөө, орон нутаг, гадаад улс руу зугтах боломжтой байdag.

Тухайн нутаг дэвсгэрт эрэн сурвалжлагдаж буй этгээдийн талаар цахим орчинд мэдээлснээр ард иргэдэд айдас төрүүлэх, сэтгэл зүйн дарамт, түгшүүртэй байдлыг бий болгох сул талтай.

Мөн найрсаг зан, өрөвч цайлган сэтгэлтэй ард иргэд эрэн сурвалжлагдаж буй хүнийг өрөвдөх, хоол хүнс, уналга зэрэг шаардлагатай зүйлсээр туслацаа үзүүлж, үйл ажиллагаанд саад учруулдаг байж болзошгүй.

Техник-технологийн орчны сул тал:

Эрүүгийн процессын эрэн сурвалжлах ажиллагаанд техник-технологийн хүчин зүйлс чухал үүрэг гүйцэтгэдэг. Гэсэн хэдий ч хөдөө, орон нутагт тэр дундаа алслагдсан сум, баг, хороодод үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчид суурин компьютерын үзүүлэлт, интернэт сүлжээний асуудлаас болж Цагдаагийн байгууллагын эрэн сурвалжлах “ASAP” сангийн мэдээллийг хожимдож авах, гацах зэрэг хүндрэл тулгардаг. Энэ нь гэмт хэрэгт эрэн



МОНГОЛ УУДААСАН ХУУЛЬ САХИУЛАХАЙ

сурвалжлагдаж буй этгээдийг шуурхай олж тогтоох, илрүүлэхэд саад учруулдаг.

Хуулийн орчны сүл тал:

Монгол Улсад мөрдөж буй хууль тогтоомжоор мөрдөн шалгах ажиллагааны хугацаа, процесс нь хэрэгжүүлэгч олон субъект дамждаг, тэдгээрийн хяналт, яллах дүгнэлт, шилжүүлэх тогтоол, шийдвэр зэрэг эрх зүйн баримт бичиг боловсруулагдах дамжлагаас хамаарч эрүүгийн процесс дахь эрэн сурвалжлах ажиллагаа гэмт хэрэг гарснаас шүүхийн шийдвэр гаргах хүртэл хугацаанд удаан үргэлжилдэг. Энэ хугацаанд сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас удаа дараа оргон зайлсан эрэн сурвалжлах ажиллагааг дахин явуулж байгаа асуудал гардаг.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд “Яллагдагч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулахгүй байх, түүнийг дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор тогтоосон газар, нутаг дэвсгэрээс гарч явах, Монгол Улсын хилээр гaraхыг хязгаарлах, тодорхой газар очих, тодорхой хүнтэй уулзахыг хориглох, тогтоосон замаар зорчихыг яллагдагчид даалгаж, хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээг авах эсэхийг прокурорын саналыг үндэслэн шүүх шийдвэрлэнэ” (Legalinfo, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2017) гэж заасан байдаг. Сэжигтэн, яллагдагч бүрт дээрх таслан сэргийлэх арга хэмжээг авдаггүй учир орон нутаг, гадаад улс руу зугтах тохиолдол их байна.

“Иргэд, байгууллагаас төлбөртэй мэдээлэл авахад баримтлах үнэлгээний жишиг” (Хууль зүй, дотоод хэргийн сайд, Сангийн сайдын 2017 оны А-297,360 дугаар хамтарсан тушаал.) -ийн шалгуурт эрэн сурвалжлагдаж буй хүнийг тусгаагүй нь учир дутагдалтай байдаг.

Хүчингүй болсон Эрүүгийн хуульд “Таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан сэжигтэн прокурорын хяналт, шүүх, цагдан хориход ос оргосон, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүн таслах ажиллагаанаас зориуд зайлсхийсэн бол гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” (Legalinfo,

Эрүүгийн хууль, 2002) гэж заасан байсан. Харин одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хуульд “Баривчлагдсан, цагдан хоригдсон яллагдагч, цагдан хоригдсон шүүгдэгч, эсхүл хорих ял шийтгүүлсэн ялтан оргон зайлсан бол зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” (Legalinfo, Эрүүгийн хууль, 2015) гэж заасан нь сэжигтний үүрэг, хариуцлагыг сулруулсан гэж үзэж болохоор байна.

Хүрээлэн буй орчны сүл тал:

Манай улс өргөн уудам нутагтай тул эрэн сурвалжлагдаж буй этгээд алслагдмал суурин газар, ой хээр, бүс нутагт орогнох, суурьших, байгалийн эрс тэс уур амьсгалтай тул давагдашгүй хүчин зүйлийн улмаас эрэн сурвалжлах ажиллагаа удаашруулах, хугацаа алдах байдлыг бий болгодог. Жишээлбэл:

-Алслагдсан суурин газрууд руу хүрэх зам, тээврийн дэд бүтэц муу хөгжсөн, зарим бүс нутагт замын нөхцөл хүнд, тээврийн хэрэгслийн боломж хязгаарлагдмал байдаг тул эрэн сурвалжлах ажиллагаа удааширдаг;

-Алслагдсан бүс нутагт харилцаа холбооны сүлжээний хамрах хүрээ муу, зарим газарт огт сүлжээ байдаггүй тул мэдээлэл солилцоо удааширч, эрэн сурвалжлах ажиллагааны уялдаа холбоо алдагддаг;

-Байгалийн гамшиг, үер, цасан шуурга зэрэг давагдашгүй хүчин зүйлсээс шалтгаалан эрэн сурвалжлах ажиллагаа удааширч, зарим тохиолдолд түр зогсох хүртэл нөхцөл байдал үүсдэг;

Хоёр. ГАДААД ОРЧНЫ ХҮЧИН ЗҮЙЛ

Эрүүгийн процессын эрэн сурвалжлах ажиллагаанд үзүүлэх улс төр, эдийн засаг, нийгэм-соёл, техники-технологи, хууль, хүрээлэн буй орчны гадаад орчны нөлөөллийн шинжилгээ хийлээ.

3. БОЛОМЖ

Улс төрийн боломж: Олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлснээр гадаадын хууль сахиулах байгууллагуудтай илүү нягт хамтран ажиллах нөхцөл бүрдэж, гэмт хэрэгтэй тэмцэх тэр дундаа эрэн

сурвалжлах ажиллагаанд олон улсын тэргүүн туршлага, дэвшилтэй арга барилыг нэвтрүүлэх, гэмт этгээдийг олж тогтоох, баривчлах үйл ажиллагааг илүү үр дүнтэй зохион байгуулах, олон улсын итгэлцлийг нэмэгдүүлэх боломжтой.

Жишээлбэл: Сингапурын “**Home Team**” нь улсын дотоодын аюулгүй байдлыг хангах чиг үүрэгтэй хэд хэдэн гол байгууллагуудын хамтын ажиллагааны сүлжээ бөгөөд энэхүү багт Цагдаагийн газар (Singapore Police Force), Шоронгийн Алба (Singapore Prison Service), Иргэний батлан хамгаалах алба (Singapore Civil Defence Force), Төвийн хар тамхитай тэмцэх товчоо (Central Narcotics Bureau), Цагаачлал ба Шилжилт хөдөлгөөний алба (Immigration and Checkpoints Authority), Газар хөдлөлт, Галын алба (Singapore Civil Defence Force) зэрэг байгууллагууд багтдаг, тус улсын Дотоодын хэргийн яамны (Ministry of Home Affairs, MHA) удирдлага дор ажилладаг байна. Эдгээр байгууллагууд хамтын ажиллагааны хүрээнд Сингапурын нийгэмд аюулгүй байдлыг хангах, хууль ёсыг сахиулах, гамшгийн хариу арга хэмжээ авах зэрэг олон чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төдийгүй эрэн сурвалжлах ажиллагааг ч түргэн шуурхай, үр дүнтэй зохион байгуулдаг. (www.mha.gov.sg/home.)

Дээр дурдсан тэргүүн туршлагын дагуу манай улсад эрэн сурвалжлах ажиллагааг зохион байгуулахад голлох үүрэг гүйцэтгэх байгууллагуудын “Нэгдсэн баг”-ийг байгуулснаар уг ажиллагааг дотоодын хэмжээнд түргэн шуурхай хэрэгжүүлэх, мэдээ мэдээллийг дамжуулах, солилцох, гэмт этгээдийг богино хугацаанд олж тогтоох, цаг хугацаа, төсөв хөрөнгө хэмнэх, цагдаагийн алба хаагчдын ажлын ачааллыг багасгах зэрэг олон давуу тал, боломжтой.

Эдийн засгийн боломж: Эрэн сурвалжлах ажиллагааны өнөөгийн зардлыг бууруулж, иргэд, олон нийтийн оролцоо, хамтын ажиллагаагаар зохион байгуулах нь улс орны эдийн засгийг сайжруулах, төсвийн хөрөнгийг хэмнэх боломжтой.

Нийгэм-соёлын орчны боломж:

Цагдаагийн байгууллагын эрэн сурвалжлах ажиллагааны талаарх мэдээ, мэдээллийг эерэг, тохиромжтой хэлбэрээр иргэдэд тогтмол хүргэж, уг ажиллагааг иргэд, олон нийтийн оролцоотойгоор хамтран зохион байгуулбал хүн хүч, төсөв хөрөнгө хэмнэх боломжтой.



ИХЭВЧЛЭЛ

Техник-технологийн орчны боломж:

Боломж: Мэдээллийн технологийн дэвшил, хиймэл оюун ухаанд суурилсан техник технологи, камержуулалтын систем, дижитал платформуудыг ашиглан эрэн сурвалжлах ажиллагааг сайжруулах, мэдээлэл солилцох, хамтран ажиллах процессыг хөнгөвчлөх боломжтой. Жишээ нь: Эрэн сурвалжлагдаж буй хүний биометрийг ашиглан хиймэл оюун ухаанд суурилсан камержуулалтын системийн тусламжтайгаар тухайн хүний явсан газруудын байршил, маршрут, чиглэлийг тодорхойлж, богино хугацаанд илрүүлэх, олж тогтоох боломжтой.

Хуулийн орчны боломж: Мөрдөн шалгах ажиллагааны Шүүх төвтэй тогтолцооны тухайд мөрдөн шалгах, эрэн сурвалжлах үүрэг бүхий байгууллагын гүйцэтгэх чиг үүрэг нь гэмт хэргийг газар дээр нь материалжуулах явдал бөгөөд ихэвчлэн 72 цагийн дотор шүүхэд шилжүүлэх хуулийн зохицуулалттай байдаг (Dr. Anand. K. Deshmunk, Adversarial and Inquisitorial Models of Criminal Justice System: A Comparative Analysis, International Journal of Legal Science & Innovation, 2022). Өөрөөр хэлбэл, хэргийн газарт ирсэн алба хаагч тогтоогдвол зохих бүх нөхцөл байдлыг шалгаж, шүүхэд материалыг шилжүүлэх эсэхийг тэр дор нь шийдвэрлэсэн байхыг шаардах бөгөөд үүнийг дагаад эрэн сурвалжлах ажиллагааны үргэлжлэх процессын хүрээ ч богино хугацаатай байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн ихэнх хувийг эзэлдэг ахуйн чанартай, эзэнтэй хэргүүдийг газар дээр нь шуурхай материалжуулан шалгаснаар тухайн хэргийг тасаг, хэлтэс рүү дамжуулан ажиллагаанд шилжүүлэх, хэргийн холбогдогч, хохирогч нар цагдаагийн газар руу дахин дуудагдах, сэжигтэн оргон



МОНГОЛ УУДААЛЫГ БҮРДЭХ САХИУЛАХАЙ

зайлах зэрэг дараачийн шатны хүндрэлүүд илт буурч, зардал хэмнэгддэг тул барууны эрүүгийн процесс дахь эрэн сурвалжлах ажиллагаа нь илүү зөв жишиг юм.

Хүрээлэн буй орчны боломж:

Алслагдсан суурин газруудад зам, тээврийн дэд бүтэц, харилцаа холбооны сүлжээ, техник хэрэгслийн хүртээмж, ашиглалтыг сайжруулснаар хүрээлэн буй орчны сул талыг арилгаж, давуу тал болгон ашиглах боломжтой. Өөрөөр хэлбэл эрэн сурвалжлах ажиллагааг орон зайд, үл хамааран түргэн шуурхай зохион байгуулах, эрэн сурвалжлагдаж буй этгээдийг богино хугацаанд олж тогтоох нөхцөл бүрдэнэ.

4. АЮУЛ ЗАНАЛ

Улс төрийн аюул занал: Улс төрийн орчин өөрчлөгдөх нь Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа тэр дундаа эрэн сурвалжлах ажиллагаанд сергөөр нөлөөлж болзошгүй. Тухайлбал, улс төрийн шинэ хүчин, нам эвсэл, удирдлага гарч ирэх, эсвэл Засгийн газрын бүтцийн өөрчлөлт нь хууль сахиулах байгууллагын чиг үүрэг, эрх мэдэлд нөлөөлж болох бөгөөд үүнээс үүдэн эрэн сурвалжлах ажиллагааны үр дүн буурч, хэрэгжилт удааширч болзошгүй.

Засгийн газрын баримталж буй бодлогын тогтвортгүй байдал нь эрх зүйн орчныг тодорхой бус болгож, эрэн сурвалжлах ажиллагаанд хүндрэл учруулж болзошгүй. Өөрөөр хэлбэл хууль тогтоомжийн өөрчлөлт, шинэчлэлтүүд байнга хийгдэх нь Цагдаагийн байгууллагын ажилд саад учруулж, алба хаагчдын ажиллах нөхцөлийг тодорхой бус болгож, тэдний үйл ажиллагааны үр дүнд сергөөр нөлөөлөх эрсдэлтэй.

Мөн Засгийн газрын бодлогын өөрчлөлт нь улсын төсөв, санхүүжилтэд нөлөөлж болох бөгөөд Цагдаагийн байгууллагын төсөв, хөрөнгө оруулалтын хэмжээ буурах эрсдэлтэй. Ингэснээр эрэн сурвалжлах ажиллагаанд шаардлагатай техник хэрэгсэл, боловсон хүчний сургалт, хангамж дутмаг болж, үр дүн буурч болзошгүй.

Улс төрийн тогтвортгүй байдал нь Олон улсын хамтын ажиллагааг

хэрэгжүүлэхэд шаардлагатай гэрээ хэлцэл, санамж бичгүүдийг батлах, хэрэгжүүлэх үйл явцыг удаашруулах, улмаар эрэн сурвалжлах ажиллагааны хамтын ажиллагааны үр дүнд сергөөр нөлөөлж болзошгүй.

Улс төрийн орчинд үүссэн өөрчлөлтүүд нь Цагдаагийн байгууллагын ажилд иргэдийн итгэлцлийг бууруулж, хамтын ажиллагааг сулруулж болзошгүй. Энэ нь эрэн сурвалжлах ажиллагааны мэдээлэл солилцоо, хамтран ажиллахад сергөөр нөлөөлнө.

Эдийн засгийн аюул занал:

Эдийн засгийн уналт, санхүүгийн хямрал нь Цагдаагийн байгууллагын төсөв, санхүүжилтэд сергөөр нөлөөлдөг. Улсын санхүүгийн хямралын үед Засгийн газрын төсөв танагдаж, төрийн байгууллагын үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгө оруулалт буурдаг. Энэ нь эрэн сурвалжлах ажиллагааны хэрэгжилтэд нөлөөлж, тоног төхөөрөмж, программ хангамж, шаардлагатай зардлыг бууруулахад хүргэдэг.

Эдийн засгийн тогтвортгүй байдал нь Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд тодорхой бус байдал үүсгэдэг. Төсвийн тасалдал, хөрөнгө оруулалтын бууралт зэрэг нь байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг явуулахад хүндрэл учруулж, эрэн сурвалжлах ажиллагааны үр нөлөөг бууруулж болзошгүй.

Тоног төхөөрөмж, техник хэрэгслийн шинэчлэл, засвар үйлчилгээ санхүүжилтийн дутмаг байдлаас үүдэж эрэн сурвалжлах ажиллагаанд шаардлагатай техник, технологийн шинэчлэл хийгдэхгүй бол хуучирсан тоног төхөөрөмж ашиглах, эвдрэл гэмтэл гарсан тохиолдолд засварлахад хүндрэлтэй болно. Энэ нь эрэн сурвалжлах ажиллагааны үр дүнг бууруулж, гэмт этгээдийг түргэн шуурхай олоход саад учруулж болзошгүй.

Нийгмийн аюул занал: Эрэн сурвалжлагдаж буй этгээд алслагдмал суурин газар, ой хээр, бус нутагт орогнох, суурьших боломжтой төдийгүй ард иргэдийн найрсаг зан, өрөвч цайлган сэтгэлийг ашиглах, цаашлаад дахин гэмт хэрэг үйлдэх эрсдэлтэй байдаг.



МОНГОЛ УСАГДЫН ХУВЬСААЛЫН ААНЫН
ХАРЭЭЛЭН БҮЙ ОРЧНЫ АЮУЛ ЗАНАЛ

Техник-технологийн орчны аюул занал:

Манай улсын алслагдсан газар нутагт оршин суудаг, ухаалаг гар утас, интернэт, цахим мэдээллийн хэрэгсэл ашигладаггүй иргэд эрэн сурвалжлагдаж буй этгээдийн талаар мэдээлэлгүйн улмаас амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөөрөө хохирч болзошгүй.

Хуулийн орчны аюул занал:

Улс орнуудын хууль, эрх зүйн тогтолцооны ялгаатай байдал нь гэмт хэрэгтнүүдийг хил дамнан эрэн сурвалжлах ажиллагаанд саад учруулж болох аюултай. Тухайлбал, гэмт хэрэгтнүүд нэг улсын хуульд нийцэхгүй буюу тэнд ял шийтгүүлэхгүй байх боломжийг ашиглаж, тухайн улс руу оргон зайлах тохиолдол гарч болзошгүй. Жишээ нь: Зарим улс орнууд ялтан шилжүүлэн өгөх гэрээнд оролцдоггүй тул гэмт этгээд тухайн улсад оргон зайлж, баривчлагдахгүй байх боломжтой.

Зарим улс орнууд хооронд сэжигтэн, яллагдагчийг шилжүүлэх гэрээ байгуулдаггүй бөгөөд энэ нь гэмт этгээдийг нэг улсаас нөгөө улс руу шилжүүлэн өгөхөд саад болдог. Тиймээс гэмт этгээд өөр улс руу зугтаж, тухайн улсад хуулийн хариуцлагаас зайлсхийж чаддаг. Жишээ нь: Хоорондоо сэжигтэн, яллагдагч

шилжүүлэх гэрээ байхгүй хоёр улсын хооронд баривчилгаа, шилжүүлэлт хийх боломж хязгаарлагдмал тул гэмт этгээд оргон зайлахад дөхөм болдог.

Хүрээлэн бүй орчны аюул занал:

Манай улсын нутаг дэвсгэрийн хэмжээ том, хүн амын нягтрал багатай учир эрэн сурвалжлагдаж буй этгээд алслагдсан, хүн ам цөөнтэй бус нутагт нуугдах боломжтой төдийгүй алслагдсан суурин газрууд, уул, ой модтой бүсүүд нь гэмт этгээдийг олоход хүндрэл учруулах эрдэлтэй.

Эрэн сурвалжлах ажиллагаа явуулахад шаардлагатай хүн хүч, техник хэрэгсэл нь том газар нутгийн хувьд хязгаарлагдмал байдаг тул ажиллагааны үр дүнд сергөөр нөлөөлж болзошгүй.

Манай улс эрс тэс уур амьсгалтай, улирлын онцлог ихтэй тул өвөл, зуны улиралд температурын зөрүү их, хүйтэн өвөл, халуун зун, хүчтэй салхи, цасан шуурга зэрэг байгалийн үзэгдлүүд нь алба хаагчдын ажиллах нөхцөлийг хүндрүүлж, эрэн сурвалжлах ажиллагааны хугацааг сунгах, техник хэрэгслийн ажиллагаанд соргоор нөлоолж болзошгүй байдаг.

SWOT/PESTLE шинжилгээ болон тодорхойлсон хүчин зүйлсийн иж бүрэн хураангуйг бүтцээр харуулав. (Зураг 2)

PESTLE/SWOT	Дотоод хүчин зүйл/Internal	
	Давуу тал/Strengths	Сүл тал/Weakness
Political	SP1 Олон улсын байгууллагуудын хамтын ажиллагаа SP2 “Эрэн сурвалжлах ажиллагаа” нь аливаа улс төрийн нөлөөнөөс үл хамаардаг.	PW1 Төрөөс тогтоосон үйл ажиллагааны чиглэлийн дагуу ачаалал ихтэй ажилладаг. PW2 Мэргэжлийн боловсон хүчин дутагдалтай.
Economical	EcS1 Эрэн сурвалжлах ажиллагааны зардлын эдийн засгийн баталгааг хуулиар баталгаажуулж өгсөн. EcS2 Зардлыг инфляцитай уялдуулсан.	EcW1 Зардлын баримт бичгийг хаах нь олон шат дамжлагатай. EcW2 Эрэн сурвалжлагдаж байгаа хүний мэдээллийг төлбортэй авах талаар тусгаагүй.
Social	SS1 Олон нийтийн дэмжлэг, хамтын ажиллагаа сайн	SW1 Олон нийтэд айдас, сэтгэл зүйн дарамт, түгшүүртэй байдлыг бий болгодог. SW2 Хүн амын найрсаг, өрөвч сэтгэл нь эрэн сурвалжлагдаж байгаа хүнд туслалцаа үзүүлж үйл ажиллагаанд саад учруулдаг.
Technological	TS1 Мэдээллийн нэгдсэн сантай.	TW1 Газар зүйн байршилаас хамаарч интернэт сүлжээ доголдох, гацах асуудал үүсдэг.



МОНГОЛ УУДААСАН ХУУЛЬ САХИУЛАХҮЙ

		TW2 Программ хөгжүүлэлт дутагдалтай
Legislative	LS1 Хууль эрх зүйн орчны дэмжлэг их	LW1 Мөрдөн шалгах ажиллагааны хугацаа шүүхийн шийдвэр гартал уддаг учраас оргон зайлх явдал их гардаг. LW2 Оргон зайлсан тохиолдолд хүлээлгэх шийтгэл өмнөхөөсөө буурсан.
Environmental	ES1 Хүн амын суурышлын бүс нийт нутаг дэвсгэрийн 12.7 хувийг эзэлдэг.	EW1 Алслагдсан бүс нутаг рүү хүрэх дэд бүтэц муу EW2 Байгалийн гамшигт үзэгдлийн давтамж ойртсон нь эрэн сурвалжлах юйл ажиллагааг удаашруулдаг.
Гадаад хүчин зүйл/External		
	Боломж/Opportunities	Аюул занал/Threats
Political	PO1 Олон улсын тэргүүн туршилага, дэвшилтэт арга барилыг нэвтрүүлэх	PT1 Бүс нутгийн геополитикийн тогтвортгүй байдал
Economical	EO1 Олон улсын эрэн сурвалжлах байгууллагаас эдийн засгийн дэмжлэг авах боломжтой.	ET1 Валютын ханшны тогтвортгүй байдал
Social	SO1 Мэдээ, мэдээллийн хэрэгслийн тусламжтайгаар иргэд, олон нийтийг оролцоог нэмэгдүүлэх	ST1 Алслагдсан суурин газар, ард иргэдийн ахуй амьдралыг дахин гэмт хэрэг үйлдэхэд ашиглах эрсдэлтэй
Technological	TO1 Технологийн интеграцилал бүхий шилэн өргтгийн сүлжээ TO2 Хиймэл оюун ухаанд сууриссан техник технологи, камержуулалтын систем, дижитал платформууд	TT1 Кибер-аюулгүй байдлын эрсдэл TT2 Харилцaa холбоо, цахим сүлжээний хүрэлцээ, хангамж дутмаг
Legislative	LO1 Олон улсын гэрээ, конвенцтой уялдуулах	LT1 Улс орнуудын эрх зүйн орчны ялгаатай байдал LT2 Сэжигтэн яллагдагчийг шилжүүлэх гэрээ улс орон болгонд өөр.
Environmental	EO1 Байгальд ээлтэй технологи нэвтрүүлэх	ET1 Уур амьсгалын өөрчлөлт ба хүрээлэн буй орчны бохирдол

Зураг 2. Эрэн сурвалжлах ажиллагааны SWOT/PESTLE шинжилгээ

Тайлбар: Судлаачдын тооцоолсноор

Дүгнэлт

Цагдаагийн байгууллагын эрэн сурвалжлах ажиллагааны өнөөгийн байдлын гадаад, дотоод орчны SWOT/PESTLE шинжилгээний үр дүнгээс дараах дүгнэлтүүдийг хийж байна. Үүнд:

Цагдаагийн албаны тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Гүйцэтгэх ажлын тухай хуулиудад “Эрэн сурвалжлах ажиллагаа”-ны талаар хуульчилж, Застийн газраас олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх, уг ажиллагааны чанар, үр дүн, санхүүжилтийг нэмэгдүүлэх, ажиллах орчин, нөхцөлийг сайжруулах чиглэлээр дэмжлэг үзүүлж,

эрэн сурвалжлагдаж буй этгээдийг шуурхай олж илрүүлэхэд анхаарал хандуулж байгаа хэдий ч мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх ажил хоцрогдож, алслагдсан суурин газарт дэд бүтэц хөгжөөгүй, техник технологи, цахим сүлжээний хүрэлцээгүй байдал эрсдэл дагуулж болзошгүй байна.

Эрэн сурвалжлах ажиллагаанд “ASAP” санг ашиглаж эхэлснээс хойш цугларсан мэдээллээс авч үзэхэд илрүүлэлт 92.6 хувьтай байгаа нь сайн үзүүлэлт боловч өнөөгийн нөхцөл байдалд уг ажиллагааг Цагдаагийн байгууллага хариуцан хэрэгжүүлж байгаа нь алба



хаагчдын ажлын ачаалалд ихээхэн нөлөөлдөг гэж үзэж болохор байна.

Цаашид эрэн сурвалжлах ажиллагааг Цагдаагийн байгууллагын чиг үүрэг, хүн хүчээр зохион байгуулах бус уг ажиллагааг хэрэгжүүлэхэд голлох чиг үүрэгтэй байгууллагуудын оролцоотойгоор зохион явуулдаг Олон Улсын тэргүүн туршлага, үйл ажиллагааны оновчтой хэлбэрийг нэвтрүүлэх нь ач холбогдолтой гэж үзэж байна.

SWOT/PESTLE шинжилгээг бизнесийн салбарт төдийгүй хууль, эрх зүйн салбарт өргөн ашиглах боломжтой бөгөөд манай улсын хувьд эрэн сурвалжлах ажиллагааг гадаад, дотоод орчны олон хүчин зүйлээс хамааруулан судалсан энэхүү ажил нь анхны удаагаа хийгдэж байгаагаараа онцлог юм.

Эрэн сурвалжлах ажиллагааны дотоод орчны давуу, сул талууд болон боломж, аюул занал нь харьцангуй тодорхойлогдох боломжтой байсан бөгөөд гадаад орчны хамаарал нь цөөн байгаа нь цаашид энэ сэдвээр судалгаа, эрдэм шинжилгээний ажлыг олон улсын түвшинд судлах зайлшгүй шаардлагатайг харуулж байна.

Уг шинжилгээгээр илрүүлсэн хүчин зүйлүүдийн шалтгаан, үр дагаврыг математик статистикийн аргыг ашиглан гүнзгийрүүлэн судлах, бодлогын судалгаа боловсруулахад энэхүү ажил нь үндсэн суурь мэдээлэл болох учраас судалгаа, шинжилгээний ач холбогдолтой үзүүлэлт болно.

Санал

- Цагдаагийн албаны тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Гүйцэтгэх ажлын тухай хуулиудад “Эрэн сурвалжлах ажиллагаа”-ны талаар тодорхой хуульчилж, нэгдсэн ойлголтыг төгөлдержүүлэх;

- Засгийн газраас “Эрэн сурвалжлах” чиглэлийн олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх, энэ чиглэлээр олон улсын туршлагыг ном болгон хэвлэж, практик ажилд нэвтрүүлэх;

- Мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх ажилд анхаарч, ДХИС-ийн

хичээлийн иж бүрдлүүдэд хяналт хийж, энэ чиглэлийн боловсруулалтыг сайжруулах;

- Алслагдсан суурин газарт дэд бүтэц, техник технологи, цахим сүлжээний хүрэлцээг нэмэгдүүлэх арга хэмжээ авах;

- Цаашид эрэн сурвалжлах ажиллагааг Цагдаагийн байгууллагын чиг үүрэг, хүн хүчээр зохион байгуулах бус уг ажиллагааг хэрэгжүүлэхэд голлох чиг үүрэгтэй байгууллагуудын оролцоотойгоор иргэдийг түшиглэн зохион явуулдаг Олон Улсын тэргүүн туршлага, үйл ажиллагааны оновчтой хэлбэрийг нэвтрүүлэх зэрэг болно.

Ашигласан материал

- Монгол Улсын Их Хурал. (1997). *Гүйцэтгэх ажлын тухай хууль.* Улаанбаатар.
- Монгол Улсын Их Хурал. (2002). *Эрүүгийн хууль.* Улаанбаатар.
- Монгол Улсын Их Хурал. (2015). *Эрүүгийн хууль.* Улаанбаатар.
- Монгол Улсын Их Хурал. (2017). *Цагдаагийн албаны тухай хууль.* Улаанбаатар.
- Монгол Улсын Их Хурал. (2017). *Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль.* Улаанбаатар.
- Монгол Улсын Их Хурал. (2021, June 22). *Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль.* Улаанбаатар.
- Монгол Улсын Засгийн газар. (1991). *ОУЦБ-Интерполд гишүүнээр элсэх тухай хуралдааны протокол.* Улаанбаатар.
- Монгол Улсын Засгийн газар. (2023). *2023-2024 оныг авлигатай тэмцэх жил болгон зарлах тухай (49-р тогтоол).* Улаанбаатар.
- Хууль зүй, дотоод хэргийн яам. (2017). *Сайдын тушаал А-297, 360 дугаар “Жишиг батлах тухай” хамтарсан тушаал.* Улаанбаатар.
- Цагдаагийн ерөнхий газар. (2021). *Монгол Улсын цагдаагийн байгууллагын түүх.* Улаанбаатар: Соёмбо хэвлэлийн газар.
- Цагдаагийн ерөнхий газар. (2024). *Эрэн сурвалжлах журам.* Улаанбаатар.
- Цагдаагийн ерөнхий газар. (2012). *Даргын 234-р тушаал.* Улаанбаатар.



МОНГОЛ УСГЫН
ДАШТЫН ТӨХВИЛДҮҮСНӨЛҮҮК
САНЧААНЫ СИСТЕМЧИЛГЭЭН
СОХИУЛАХҮҮД

- Цагдаагийн ерөнхий газар. (2011). *Цахимсан*. Улаанбаатар.
- Deshmukh, D. K. (2022). *Adversarial and inquisitorial models of criminal justice system: A comparative analysis*. *International Journal of Legal Science and Innovation*, 70–77.
- www.1212.mn. (n.d.). Retrieved from <https://www.1212.mn>

Ministry of Home Affairs Singapore. (n.d.).

Retrieved from <https://www.mha.gov.sg>

World Population Review. (n.d.). Retrieved from

<https://www.worldpopulationreview.com>

Лхагварагчaa, Б., & Пүрэвсүрэн, Э. (2021).

Эрүүгийн процессын эрх зүй.

Улаанбаатар: Соёмбо хэвлэлийн газар.